



МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР

ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР

2-201 тоот, Энхтайван найрамдлын ордон, 3 дугаар хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот
Утас: 7000-0695

E-mail: mongolnaadam@mnts.ub.gov.mn


2020.01.06 № 1
танай _____-ны № _____-т

**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАРТ**

“Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын
2019 онд төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн
шууд захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээний
биелэлтийг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт.....хуудастай.

ДАРГА  Д.ХАТАНБААТАР



215030338

**“МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР” ОНӨТҮГ-ЫН ДАРГА Д.ХАТАНБААТАРЫН ҮР
ДҮНГИЙН ГЭРЭЭНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТИЙГ ДҮГНЭХ
(ИЛТГЭХ ХУУДАС)**

НЭГ. ТАЛУУДЫН ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ

1. Төсвийн шууд захирагчийн үүргийн биелэлт

1.1. Төсвийн шууд захирагчийн үр дүнгийн гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-ний хавсралт болох байгууллагын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө”-нд тусгагдсан тусгай арга хэмжээнээс бусад **34 нийт арга хэмжээ (гарц)-ний** хэрэгжилтийг арга хэмжээ тус бүрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүн)-ийн хүрсэн түвшинг гэрээнд тусгагдсан шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшинтэй харьцуулан дүгнэх үндсэн дээр дор дурдсан дундаж оноогоор үнэлэв:

Хүснэгт 1

| <i>Тусгай арга хэмжээнээс бусад хэрэгжүүлбэл зохих нийт арга хэмжээний тоо</i> | <i>Өгвөл зохих оноо</i> | <i>Өгсөн оноо /дундаж оноо/</i> |
|--|-------------------------|---------------------------------|
| 1 | 2 | 3 |
| 2 | 0-30 | |

1.2. Гэрээний хавсралт болох “Байгууллагын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө”-нд тусгагдсан арга хэмжээнээс төсвийн ерөнхийлөн захирагчийн тусгайлан сонгосон **10 тусгай арга хэмжээ (гарц)-ний** хэрэгжилтийг арга хэмжээ тус бүрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүн)-ийн хүрсэн түвшинг гэрээнд тусгагдсан шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшинтэй харьцуулан дүгнэх үндсэн дээр дор дурдсан дундаж оноогоор үнэлэв:

Хүснэгт 2

| <i>Хэрэгжүүлбэл зохих тусгай арга хэмжээний тоо</i> | <i>Өгвөл зохих оноо</i> | <i>Өгсөн оноо /дундаж оноо/</i> |
|---|-------------------------|---------------------------------|
| 1 | 2 | 3 |
| 4 | 0-40 | |

1.3. **Манлайллын зорилт (орц)** бүрийн биелэлт, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт бүрийн хүрсэн түвшинг гэрээнд тусгагдсан шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшинтэй харьцуулан дүгнэх үндсэн дээр дор дурдсан дундаж оноогоор үнэлэв:

Хүснэгт 3

| <i>Манлайллын зорилт (орц)-ын тоо</i> | <i>Өгвөл зохих оноо</i> | <i>Өгсөн оноо /дундаж оноо/</i> |
|---------------------------------------|-------------------------|---------------------------------|
| 1 | 2 | 3 |
| 5 | 0-30 | |

1.4. Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт /өөрийгөө хөгжүүлэх/-ын биелэлт:

Удирдлагын менежментийн ур чадвараа дээшлүүлэн өөрийгөө хөгжүүлэн Засгийн газрын хэрэг эрхлэх газрын харьяа Удирдлагын академид суралцаж, Удирдахуйн ухааны магистрийн зэрэг хамгаалсан.

1.5 Тухайн төсвийн шууд захирагчийн төрийн алба, төрийн албан хаагчтай холбоотой **хууль тогтоомж стандартыг мөрдөж ажилласан тухай дүгнэлт:**

.....

2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн үүргийн биелэлт:

.....

ХОЁР. ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТИЙГ ҮНЭЛГЭЭ, ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

3. Гэрээний биелэлтийг үнэлгээ

3.1 Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн шууд захирагчийн гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтийг дүгнэж, дор дурдсан дундаж оноогоор үнэлэв:

Хүснэгт 4

| <i>Гэрээний үзүүлэлт</i> | <i>Өгвөл зохих оноо</i> | <i>Өгсөн оноо /дундаж оноо/</i> |
|---|-------------------------|---------------------------------|
| 1.Нийт арга хэмжээ (гарц)-ний биелэлт | 0-30 | |
| 2.Тусгай арга хэмжээ (гарц)-ний биелэлт | 0-40 | |
| 3. Манлайллын зорилт (орц)-ын биелэлт | 0-30 | |
| Нийт оноо | 0-100 | |

3.2. Төсвийн ерөнхийлөн захирагч гэрээний биелэлтийг дүгнэж өгсөн үнэлгээгээ гэж тэмдэглэнэ.

Хүснэгт 5

| "А" буюу маш сайн | "В" буюу "Сайн" | "С" буюу хангалттай | "D" буюу Дутагдалтай | "F" буюу Хангалтгүй |
|-------------------|-----------------|---------------------|----------------------|---------------------|
| | | | | |

Хэрэв "А" буюу "Маш сайн" эсхүл "D" буюу "Дутагдалтай", "F" буюу "Хангалтгүй" гэсэн үнэлгээ өгсөн бол энэ тухай үндэслэлээ бичнэ.

.....
.....
.....

4. Гэрээний биелэлтийн үнэлгээг үндэслэн хэрэгжүүлэх арга хэмжээний санал:

1.
.....

2.
.....Г.М.

Гэрээний биелэлтийн үнэлгээний баталгаажуулалт:

5.1. Үнэлгээ өгсөн:

Үнэлгээ өгсөн:

Төсвийн ерөнхийлөн захирагч:

Нийслэлийн Засаг дарга бөгөөд

Улаанбаатар хотын захирагч

...../ С.АМАРСАЙХАН/

2020 оны 1 дүгээр сарын өдөр

5.2. Үнэлгээтэй танилцсан:

Тайлан бичсэн:

МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР
ОНӨТҮГАЗРЫН ДАРГА

.....

Төсвийн шууд захиаргч:

...../Д.ХАТАНБААТАР/

2020 оны 1 дүгээр сарынөдөр

**“МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР” ОНӨТҮГ-ЫН ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН ҮР ДҮНГИЙН
ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТИЙН ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН
2019 он**

НЭГ. НИЙТ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ:

| Гэрээнд тусгагдсан нийт арга хэмжээ тэдгээрийн шалгуур үзүүлэлт (тоо чанар хугацаа үр дүн) бүрээр хүрэх түвшин | Жинхэнэ гүйцэтгэл (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин) | Тухайн нийт арга хэмжээний биелэлтэд ерөнхийлөн захирагчийн өгсөн үнэлгээ (Нийт арга хэмжээ бүрийн биелэлтэд 0-30 оноо) |
|---|---|---|
| <p align="center">1</p> <p>Нэг. Эдийн засаг нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан үйл ажиллагаа</p> <p>Арга хэмжээ 1.1 “Хөхүүрийн айраг” Бэсрэг наадамд хамтран ажиллана. (Ажлын гүйцэтгэлээр)</p> <p>Арга хэмжээ 1.2 ERP өргөдөл гомдлын цахим системээр дамжин ирж буй өргөдөл гомдол, санал хүсэлтийг хүлээн авч хугацаанд нь шийдвэрлэн ажиллана. (Ажлын гүйцэтгэлээр)</p> | <p align="center">2</p> <p>ЗАА-ны Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтсийн захиалгаар “Хөхүүрийн айраг” арга хэмжээнд 1 ширхэг 5 ханатай гэр, 3*4 хэмжээтэй лед дэлгэц, 6*8-ийн хэмжээтэй монгол майхан зэргийг Соёлын наадмын талбайд байршуулан 07 дугаар сарын 11, 12-ны өдрүүдэд лед дэлгэцтэй бүрэн хариуцан ажиллуулсан.</p> <p>“Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын захиргаа, санхүүгийн алба, маркетингийн албаны албан хаагчид өргөдөл, гомдлын нэгдсэн цахим систем болох eg.uiaa.mn сайтыг өдөр бүр тогтмол шалгадаг бөгөөд байгууллагын хэмжээнд иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдол, санал, хүсэлт байхгүй бөгөөд байгууллагын дотоод асуудлаар ажилтнуудын хандсан өргөдөл, хүсэлтийг хуулиар тогтоосон хугацаанд шийдвэрлэн ажиллаж байна.</p> <p>2019 онд нийт 195 өргөдөл, гомдол бүртгэгдсэнээс цалинтай чөлөө хүсэх тухай 3, ажлаас чөлөөлөгдөх тухай 23, ажилд томилогдох тухай хүсэлт 22, ажилд шилжүүлэн томилогдох тухай хүсэлт 10, ээлжийн амралт хүсэх тухай 29, хуушуур худалдаалах болон соёлын талбайн түрээсийн тухай хүсэлт нийт 108 ирсэн байна.</p> <p>“Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-т 2019 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн байдлаар нийт 195 өргөдөл гомдол ирснийг бүрэн шийдвэрлэж ажилласан байна. Харин шийдвэрлэх хугацаандаа Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/1086 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх</p> | <p align="center">3</p> |

| | |
|--|--|
| <p>Арга хэмжээ 1.3 Байгууллагад ирсэн өргөдөл, гомдлыг цахим болон бусад хэлбэрээр хүлээн авч, шуурхай шийдвэрлэхэд хяналт тавьж ажиллана. (Ажлын гүйцэтгэлээр)</p> <p>Арга хэмжээ 1.4 Байгууллагад дотоод хяналт, шалгалтын төлөвлөгөө боловсруулан батлуулж, гүйцэтгэл үр дүнг тооцон тайлагнаж ажиллана. (Ажлын гүйцэтгэлээр)</p> | <p>журам"-ын хэрэгжилтийг хангаж ажиллаагүйн улмаас нийт 99 өргөдөл гомдолд 397 зөрчил тооцогдоод байна. Үүнээс хугацаандаа буюу ажлын 8 цагийн хугацаандаа шийдвэрлээгүй 376 зөрчил, 10 хоногийн хугацаанд тэмдэглэл хөтлөөгүй 21 зөрчил илрээд байна. Энэ зөрчлийн дагуу Нийслэлийн Засаг даргын тамгын газрын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн даргын 2019 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 10/4290 тоот албан бичгээр 115 тоот зөвлөмж ирүүлсний дагуу даргын зөвлөлийн хуралд танилцуулж ажилласан. Энэхүү зөвлөмжийн дагуу даргын зөвлөлийн хурлаас холбогдох албан тушаалтнуудад сануулах арга хэмжээг авч ажилласан.</p> <p>Байгууллагын дотоод хяналт шалгалтын төлөвлөгөө 2 бүлэг 17 ажилтайгаар боловсруулан Улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны дотоод хяналтын хэлтсээр януулж, Байгууллагын даргаар батлуулж хэрэгжилтийг ханган ажилласан. Дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөний биелэлтийг жилийн эцсээр гаргаж 2019 оны 262 тоот албан бичгээр УБЗАА-ны дотоод хяналтын хэлтэст хүргүүлсэн.</p> |
| <p>Хоёр. Дүрмээр хүлээсэн чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа</p> <p>Арга хэмжээ 2.1 Улсын тусгай хэрэгцээнд зориулан олгосон газрын давхцлын асуудлыг шийдвэрлүүлэх ажлын хүрээнд санал боловсруулан, мэдээ мэдээлэл бэлтгэн хамтран ажиллана. (Ажлын гүйцэтгэлээр)</p> | <p>МУ-ын 3Г-ын 2015 оны 11 сарын 23-ны өдрийн 456 дугаар тогтоолоор "Монгол наадам цогцолбор"-ын хэрэгцээнд зориулан нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт хамаарах 551га, Төв аймгийн Аргалант сумын нутаг дэвсгэрт хамаарах 12,031га буюу нийт 12,582 га газрыг улсын тусгай хэрэгцээнд авах шийдвэр гарч, хилийн цэсийг тогтоож өгсөн хэдий ч 3Г-ын тогтоолоос өмнө болон хойно иргэн аж ахуй нэгжид газар олголт хийгдсэнээс газрын давхцлын асуудал үүсэж, тус газар нь дүрмээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байдал үүссэн.</p> <p>Улмаар нийслэлийн Засаг даргын 2017 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн А/890 дугаар захирамжаар "Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-т олгогдсон Улсын тусгай хэрэгцээний газрын давхцлын асуудлыг шийдвэрлэх талаар санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга Т.Гантөмөрөөр ахлуулсан ажлын хэсэг байгуулагдан ажилласан. 2019 онд тусгай хэрэгцээний газрын хэмжээ хилийн зааг өөрчлөлт орсны улмаас Төв аймгийн Аргалант сумын нутаг дэвсгэрт хамаарах 12,031 га газраас 2006 га газрыг улсын тусгай хэрэгцээний газраас чөлөөлж, шинээр 449 га газрыг нэмэх байдлаар нийт 10,474 га газрыг улсын тусгай хэрэгцээнд авах</p> |

| | |
|---|--|
| <p>Арга хэмжээ 2.2 "Монгол наадам Цогцолбор"-т зохион байгуулагдах улс, нийслэлийн шинж чанартай бусад арга хэмжээний тохижилт үйлчилгээний ажлыг хийж гүйцэтгэнэ. (Ажлын гүйцэтгэлээр)</p> | <p>асуудлыг Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 5 дугаар тогтоолоор батлуулсан. Мөн Нийслэлийн СХД-ийн нутаг дэвсгэрт хамаарах газрын асуудлыг НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, улмаар 2019 оны 12 дугаар сарын 26-ны өдөр НИТХ-аар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, Нийслэлийн Засаг даргаас засгийн газрын тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг Барилга хот байгуулалтын яаманд хүргүүлсэн.</p> <p>"Монгол Наадам Цогцолбор" ОНӨТҮГ нь Г.Пунцагбалжир агсны нэрэмжит – "Төвийн бүсийн хурдан морины уралдаан" наадмыг Хүй долоон худагт тэмдэглэн өнгөрүүлэх талаар 28 зүйлийн ажлууд төлөвлөн ерөнхий удирдагч болон Наадмын ажлын хэсгийн гишүүнээр "Монгол Наадам Цогцолбор" ОНӨТҮГ-ийн дарга Д.Хатанбаатар, Ерөнхий зохион байгуулагчаар байгууллагын орлогч дарга Р.Дашгомбо нар томилогдон ажиллаа. Уралдааны зохион байгуулалтын бэлтгэл ажлын 14 хоногийн хугацаанд ММСУХХ-той нийт 4 удаа, байгууллага дотоодоо нийт 3 удаа хуралдаж Маркетингийн хэлтсээс гаргасан 28 зүйл бүхий ажлын төлөвлөгөөний дагуу төлөвлөсөн ажлуудыг цаг хугацаанд нь хийж гүйцэтгэн тулгамдсан асуудлуудыг цаг тухайд нь шийдвэрлэж ажиллаа. Төвийн бүсийн хурдан морины уралдааны наадмыг зохион байгуулах ажлын хэсэг "Хүй долоон худаг"-т 2 удаа хуралдан талбайн тохижилт үйлчилгээнд үзлэг шалгалт хийж, морины зам засалт, морины замын усалгаа, шүдлэх морины хашаа, комиссын хашааны тохижилтын талаар шинэ санал, санаачлага гарган ярилцаж газар дээр нь асуудлуудыг шийдвэрлэж ажилласан. Хүй долоон худгийн нийтийн эзэмшлийн хуваарьт зам талбайд усалгаа, цэвэрлэгээ, цэвэр ус нийлүүлэх, бохир ус соруулах, үзэгчдийн сандал угсрах, контнейрэн нойл байрлуулах, үйлчилгээ үзүүлэх, иж бүрэн тайз хөгжим, лед дэлгэц угсрах, зэрэг ажлуудад "Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-ын 39 ажилтан, гэрээт байгууллагуудаас 15 ажилтан нийт 54 хүн, 12 экзавтобус, 11 автомашин, техник гарч ажилласан. Морь барианы талбайн тохижилтод 7*6-ын хэмжээтэй тайз, 17*7, 5-ын хэмжээтэй карказ, 6*3-ын хэмжээтэй лед дэлгэц, иж бүрэн хөгжим хэрэгслээр ханган наадмын нээлт, хаалтын үйл ажиллагааг зохион байгуулсан. Наадмын хөгжмийн техникчээр "A sound" хамтлагийн хөгжмийн</p> |
|---|--|

| | |
|--|--|
| <p>Арга хэмжээ 2.3 Баяр наадмын зохион байгуулалтад ашиглагддаг тээврийн хэрэгслийн даатгал,жолоочийн хариуцлагын даатгал,машин техникийн үзлэг оношлогоо хугацаанд нь хийлгэж аюулгүй байдлыг ханган ажиллана. (Ажлын гүйцэтгэлээр)</p> | <p>инженер Ц.Эрдэнэбаатараар ахлуулсан 4 хүний бүрэлдэхүүнтэй баг ажилласан</p> <p>"Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-ын даргын 2019 оны 06 дугаар сарын 17-ний өдөр баталсан Хүй долоон худагт Үндэсний их баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх бэлтгэл ажлыг хийж гүйцэтгэх 9 бүлэг 77 ажлыг төлөвлөгөөний дагуу байгууллагын урсгал зардлын төсвөөс 3 325 000 төгрөгөөр баяр наадмын зохион байгуулалтад ашигладаг 11 тээврийн хэрэгсэл, автомашин тоног төхөөрөмжийн үзлэг оношлогоог хийлгэж тос масло солих, эвдрэлтэй байгаа техник хэрэгсэлийг сэлбэг хэрэгслийг сольж хэвийн ажиллагаанд оруулах зэрэг ажлуудыг хийсэн.</p> |
| <p>Арга хэмжээ 2.4 Баяр наадмын зохион байгуулалтад ашиглагддаг тээврийн хэрэгсэл,автомашин тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг тухай бүрт нь хийж, ашиглалтын бэлэн байдлыг хангаж ажиллана. (Ажлын гүйцэтгэлээр)</p> | <p>Цахилгаан машин ажиллуулах зардлын төсвийг Тохижилт засвар, худалдаа, үйлчилгээний салбар хорооноос 10,658,100 төгрөгөөр баталсан. Тус захиалгат ажлыг "Өнө хангай" ХХК-тай 2019 оны 06 дугаар сарын 21-ны өдөр МНЦ 19/027 тоот цахилгаан автобусаар наадамчдад үнэ төлбөргүй үйлчлэх гэрээг байгуулсан бол "Цэнхэр харгиа" ХХК-тай 2019 оны 06 дугаар сарын 21-ны өдөр МНЦ 19/028 тоот цахилгаан автобусны аккумулятор сэргээж, тос, тослох материал сольж, завсар үйлчилгээ хийх гэрээг тус тус байгуулан хамтран ажиллаа. "Цэнхэр харгиа" ХХК-ийн хувьд нийт 16 ширхэг эко автобусны аккумуляторыг цэнэг сэргээж дагалдах тос, тослогоо болон бусад засвар үйлчилгээг хийж гүйцэтгэсэн.</p> |
| <p>Арга хэмжээ 2.5 Өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөө боловсруулан, батлуулна. (Ажлын гүйцэтгэлээр)</p> <p>Арга хэмжээ 2.6 Өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган, бэлтгэл ажлыг хийж гүйцэтгэн үр дүнг холбогдох байгууллагад тайлагнан ажиллана. (Ажлын гүйцэтгэлээр)</p> | <p>Нийслэлийн Засаг даргын 2019 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн А/503 дугаар захирамж, "Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-ын дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.10.6 дахь заалтыг тус тус үндэслэн 12 зүйл бүхий төлөвлөгөө боловсруулан 2019 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр газрын даргын А/36 дугаар тушаалын хавсралтаар батлуулсан.</p> <p>Газрын даргын 2019 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр А/36 дугаар тушаалаар батлагдсан Өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөөний дагуу хүйтний улиралд ажиллах тээврийн хэрэгслүүдийн засвар үйлчилгээг 2 071 000 төгрөгөөр хийж техникийн бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллаа. Мөн агуулахын галлагаанд зориулан "Таван толгой түлш" ХХК-аас 4,5 сая төгрөгөөр 30 тн сайжруулсан түлш, хувиарт газраас 1 машин түлшний модыг татан бэлтгэсэн. Өвөлжилтийн</p> |

| | | |
|---|---|--|
| | <p>төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хувиарын дагуу цаг хугацаанд нь бүрэн хийж, гүйцэтгэн өвөлжилтийн бэлтгэл ажлын тайлан гарган газрын даргад танилцуулсан.</p> | |
| <p>Гурав. Иргэдийн оролцоотой хөгжлийн жилийн хүрээнд болон Улаанбаатар хотын хөгжлийн индексийн шалгуур үзүүлэлтийг сайжруулах ажлын хүрээнд</p> <p>Арга хэмжээ 3.1 ҮИБН-ын Хүй долоон худаг дахь Хурдан морины уралдааны тохижилт, худалдаа, үйлчилгээний зохион байгуулалтыг сайжруулах талаар тусгай төлөвлөгөө гарган үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллана. (Ажлын гүйцэтгэлээр)</p> <p>Арга хэмжээ 3.2 "Монгол наадам цогцолбор" төслийн ерөнхий төлөвлөгөө, хэтийн зорилго, алсын харааг тодорхойлох зорилгоор</p> | <p>Морь барианы хэсгээс Соёл, урлагийн талбай хүртэлх явган хүний замын хоёр талаар болон Хоол, хүнсний талбайн эргэн тойронд зөвшөөрөлгүй худалдаа шөнийн цагаар тохижин гудамж үүсгэн гарсан байсан нь Соёл, урлагийн талбайд албан ёсны зөвшөөрөлтэйгээр гар урлал, бэлэг дурсгал, соёлын барааны худалдаа, үйлчилгээ эрхлэгч ААН, иргэдийг бүхимдуулан орлогыг хааж байсан. Тус зөвшөөрөлгүй буусан иргэдэд наадмын өдрүүдэд МНЦ-ын талбайд ажилласан зохион байгуулагчид удаа дараа албан ёсны шаардлага тавьж байсан хэдий ч хүлээж авахгүй, шаардлага биелүүлэхгүй хүндрэл учруулж байдаг. Хүй долоон худгийн үйлчилгээний талбайгаас урлагийн талбай хүртэлх дундын зайд, нийтийн автобус болон автомашины зогсоолын орчимд гар дээрээс худалдаа хийх гэсэн зөрчил тасрахгүй байгаа тул Нийслэлийн мэргэжлийн хяналтын байгууллага болон талбайд ажиллаж буй хэв журмын цагдаа нарын тоог нэмэгдүүлэх тодорхой хэмжээний дорвитой арга хэмжээ авах шаардлагатай байна. Мөн задгай худалдаа үүсгэж буй зүлэг орчмыг хашаажуулан моджуулах, зөвшөөрөлгүй худалдаа, үйлчилгээ явуулахыг хориглосон тэмдэг, тэмдэглэгээг олон тоогоор байрлуулах, Хүнс, хуушуурын талбайд үйл ажиллагаа явуулж буй ААН-үүд бохирын цооногийн гадуур хоолны хаягдал, халуун тос зэргийг замбараагүй асган цооног бөглөрүүлэн орчныг ихээр бохирдуулж байгааг шийдвэрлэх. Иймд зөвшөөрөл олгож буй холбогдох дүүрэг болон мэргэжлийн хяналтын байцаагч нар талбайд үйл ажиллагаа явуулахад шаардлагатай ариун цэврийн талаарх зааварчилгааг нарийн өгөх шаардлагатай байна.</p> <p>2019 оныг "Иргэдийн оролцоотой-Хөгжлийн жил" болгон зарласан ажлын хүрээнд "Монгол наадам цогцолбор" төслийн ерөнхий төлөвлөгөө, хэтийн зорилго, алсын харааг тодорхойлох зорилгоор байгууллагын дэргэдэх орон тооны бус бодлогын зөвлөлийн гишүүд, төрийн болон төрийн бус үндэсний спортын төлөөлүүдийг хамруулсан хэлэлцүүлэг зохион байгуулж ажлын үр дүнг байгууллагын үйл ажиллагаанд тусгаж ажиллан гэсэн заалтын дагуу 2019 оны 12 дугаар сарын 24-ний өдөр Хангарьд ордны 14 давхарт "Аялал жуучлалын төв" ТӨҮГ, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг</p> | |

байгууллагын дэргэдэх Орон тооны бус бодлогын зөвлөлийн гишүүд болон үндэсний спортын төлөөллүүдийг хамруулсан хэлэлцүүлэг зохион байгуулж үр дүнг байгууллагын ажиллагаанд тусгаж ажиллана. /Оролцогчдын тоо, ажлын гүйцэтгэлээр/

Арга хэмжээ 3.3 УИБН болон Хүй долоон удаг дахь хурдан морины уралдааны зохион байгуулалт, тохижилтыг сайжруулах зорилгоор наадмын өдрүүдэд 1000 иргэнээс судалгаа авч үр дүнг УИБН-ын Тохижилт, засвар, худалдаа, үйлчилгээний салбар хороо болон Хурдан морины салбар тус тус хүргүүлэн ажиллана. /Судалгаанд хамрагдсан иргэдийн тоо/

Арга хэмжээ 3.4 Бүх нийтээр мод тарих өдрийг тохиолдуулан Хүй долоон удагт цэцэрлэгжүүлэлт, зүлэгжүүлэлтийн ажлыг төрийн болон ТББ холбоод, сайн дурын иргэдийн оролцоотойгоор хамтран зохион байгуулна. Мөн өмнөх жилүүдэд тарьсан модонд арчилгаа хийнэ. /Хамрагдсан иргэдийн тоо, тарьсан модны тоо/

Биеийн тамир спортын газар, Нийслэлийн соёл урлагийн газар, Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Нийслэлийн Зураг төслийн хүрээлэн ОНӨАТҮГ, Улаанбаатар хөгжлийн корпораци ХК, "Монголын Морин спортын уяачдын холбоо" ТББ, "Морин спортын холбоо" ТББ, "Монголын үндэсний харваачдын холбоо" ТББ, "Монголын шагайн харвааны холбоо" ТББ, "Үндэсний бөхийн холбоо" ТББ, "Усан тэлмэн" жороо судлалын академи ТББ, "Монголын аялал жуулчлалын холбоо" ТББ, "Монголын хөнгөн атлетикийн холбоо" ТББ, "Монголын соёл, аялал жуулчлалын холбоо" ТББ, "Урлагийн залуучуудын холбоо" ТББ, Спортын төв сургууль зэрэг төрийн болон төрийн бус байгууллагуудын төлөөллийг оролцуулан хэлэлцүүлгээ амжилттай зохион байгууллаа.

"Монгол наадам цогцолборын" ОНӨТҮГ-ын 2019 оны "Гүйцэтгэлийн төлөвлөгөө"-ний дагуу Хүй долоон удаг дахь хурдан морины уралдааны зохион байгуулалт, тохижилтыг сайжруулах зорилгоор Энэ жилийн УИБН-ын өдрүүдээр буюу 07 дугаар сарын 10, 11, 12, 13-ны өдрүүдэд Хүй долоон удагт давхацсан тоогоор 45 мянга орчим хүн хүрэлцэн ирсэн бөгөөд нийт 1000 иргэнээс судалгаа авснаас 836 судалгаа хүчинтэй тоологдсон. Судалгааны тайланг УИБН-ын тохижилт, засвар, худалдаа, үйлчилгээний салбар хороо болон Хурдан морины салбар хороонд тус тус хүргүүлэхээр бэлтгсэн.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар жил бүрийн тав, аравдугаар сарын хоёр дахь долоо хоногийн Бямба гаригийг "Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр" хэмээн зарласан байдаг. Уг өдрийг тохиолдуулан 2019 оны намрын бүх нийтээр мод тарих өдрийг 10 дугаар сарын 12-ны Бямба гаригт МУ-ын Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дэргэдэх Удирдлагын академитай хамтран "Алтан намар-2019" нэртэйгээр Хүй долоон удагт "Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-ын хамт олон Удирдлагын академийн удирдлага, багш, сонсогч нартай хамтран "Голт бор"-ын суулгац 100 ширхэг, "Нохойн хошуу"-ны суулгац 100 ширхэгийг тус тус тарьж Удирдлагын академийн 2018-2019 оны элсэгчдийн төгөл байгууллаа. Мөн энэ өдөр "Монголын хүүхдийн ордон" НӨТБ, "Орон сууцны дэд бүтцийн газар", "Зорчигч тээврийн нэгтгэл" зэрэг байгууллагууд өмнөх тарьсан модныхоо тогоог сэргээн, цэнэг усалгаа хийж нийгмийн

| | |
|--|---|
| <p>Дөрөв. Дээд газраас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллах ажлын хүрээнд</p> <p>Арга хэмжээ 4.1 2019 онд Төсвийн ерөнхийлөн захирагчтай “Үр дүнгийн гэрээ” байгуулан, байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан, НӨХГ-тай “Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ” байгуулж ажиллана. Үйл ажиллагааны хэрэгжилтээр/</p> <p>Арга хэмжээ 4.2 Үр дүнгийн гэрээ, Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээний хэрэгжилтийг хангаж, биелэлтийг тогтоосон хугацаанд дээд газарт тайлагнана. Үйл ажиллагааны хэрэгжилтээр/</p> <p>Арга хэмжээ 4.3 Дээд газрын тогтоол шийдвэрийн бүртгэл, хэрэгжилтийг хяналтад авч бэлтгэлийг хугацаанд нь тайлагнаж ажиллана. Үйл ажиллагааны хэрэгжилтээр/</p> <p>Арга хэмжээ 4.4 НЗДТГ болон ЗАА-аас хяналт, шалгалтын мөрөөр өгөгдсөн зөвлөмжийн дагуу төлөвлөгөө боловсруулж гүйцэтгэлийг тайлагнан ажиллана. Үйл ажиллагааны хэрэгжилтээр/</p> | <p>хариуцлагын хүрээнд Хүй долоон хугдгийн цэцэрлэгжүүлэлтэд гар бие оролцсон.</p> <p>Төсвийн шууд захирагчаас төсвийн ерөнхийлөн захирагчтай 2019 оны 6 дугаар сард үр дүнгийн гэрээ байгуулсан бөгөөд Нийслэлийн засаг даргын 2018 оны 07 дугаар сарын 02-ны 597 тоот захирамжийн 2-т заасны дагуу Нийслэлийн өмчийн ашиглалт удирдлагын газартай “Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-г байгуулан улирал бүр үр дүнг тайлагнан ажиллаж байна.</p> <p>Нийслэлийн Засаг даргын тамгын газрын төрийн захиргаа удирдлагын хэлтэст байгууллагын даргын Үр дүнгийн гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг тус тус гаргаж Улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны дотоод хяналтын хэлтэст хүргүүлсэн. Нийслэлийн засаг даргын 2018 оны 07 сарын 02-ны 597 тоот захирамжийн 2-т заасны дагуу НӨХ-ны газартай “Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-г байгуулан улирал бүр үр дүнг тайлагнан ажиллаж байна.</p> <p>“Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-т хэрэгжиж буй УИХ-ын тогтоол 1, Засгийн газрын тогтоол 6, НИТХ-ын тэргүүлэгчдийн 2 тогтоолыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн биелэлт, үнэлгээ, тайланг эхний хагас жилийн байдлаар гарган Байгууллагын даргын дэргэдэх зөвлөлийн 2 дахь хуралдаанаар хэлэлцүүлэн 2019 оны 119 тоот албан бичгээр Нийслэлийн ЗДТГ-ын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлсэн бөгөөд Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийн жилийн эцсийн тайлан, биелэлт үнэлгээг бэлдэж байна.</p> <p>“Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын 2018 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын хэсгээс 2019 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн 03/444 тоот албан бичгээр Нийслэлийн Засаг даргын тамгын газрын хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын хэсгийн 2019 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 06 тоот зөвлөмж ирсэн. Энэхүү зөвлөмжийн дагуу ажил сайжруулах төлөвлөгөө 13 ажилтайгаар батлуулан 2019 оны 37 тоот албан бичгээр хүргүүлсэн.</p> |
|--|---|

| | |
|--|---|
| <p>Арга хэмжээ 4.5 Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн болон хотын Ерөнхий менежерийн шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг тогтоосон хугацаанд хэрэгжүүлэн тайлагнан ажиллана. /Үйл ажиллагааны хэрэгжилтээр/</p> <p>Арга хэмжээ 4.6 Байгууллагын гүйцэтгэлийн буюу /КР/И-ийн шалгуур үзүүлэлтийн журам боловсруулан хэрэгжүүлэн ажиллана. /Үйл ажиллагааны хэрэгжилтээр/</p> <p>Арга хэмжээ 4.7 Байгууллагын ажилчдын сэтгэл ханамжийн судалгаа жилд 2 удаа авч, үр дүнг тооцон ажиллана. /Авсан судалгааны тоо, үр дүн/</p> | <p>Энэ төлөвлөгөөний биелэлтийг 2019 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 137 трөт албан бичгээр хүргүүлэн ажиллаж байна.</p> <p>Улаанбаатар хотын ерөнхий менежер бөгөөд захирагчийн ажлын албаны даргын шуурхай хуралдаан 14 хоног тутамд 1 болдог бөгөөд 2019 оны эхний 11 сарын байдлаар 13 удаагийн шуурхай хуралдааны биелэлтийг хүргүүлэн ажилласан. Нийслэлийн удирдах ажилтны шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг Ulaanbaatar.mn сайтад нэвтэрч тухай бүр нь хүргүүлэн ажиллаж байна.</p> <p>Төрийн албаны тухай шинэчилсэн найруулга түүнийг дагалдан гарч буй засгийн газрын тогтоолууд, төрийн албаны зөвлөлийн тогтоол, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2019 оны 47 дугаар тушаал зэргийг тус тус дагаж мөрдөн холбогдох журмыг боловсруулан ажиллаж байна.</p> <p>Засгийн газрын 2017 оны 89-р тогтоолын дагуу жилд Байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөцийн удирдлагын асуудлуудаар бүх ажиллагсаас судалгааг авч цашид удирдлага юуг анхаарч ажиллах талаар албан хаагчдын сэтгэл ханамжийн судалгааг хоёр удаа авч ажиллаа. 2019.03.28-ны өдөр явуулсан сэтгэл ханамжийн судалгаанд "Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-ын нийт 35 ажилтан хамрагдсан бөгөөд 28 ажилтан буюу 80 хувь нь ажилдаа, 12 ажилтан буюу 34.3 хувь нь ажлын байрныхаа тав тухтай байдалд, 26 ажилтан буюу 74.3 хувь нь хэлтэс, алба хоорондын уялдаа холбоонд сэтгэл хангалуун байдаг гэсэн үр дүн гарсан байна. Тус судалгааны үр дүнг нэгтгэн дүгнэж газрын дарга, орлогч дарга болон ахлах мэргэжилтэн нарт танилцуулсан бөгөөд цашид ажлын байрны тав тухтай байдлыг сайжруулахад анхаарч ажиллахаар шийдвэрлэсэн. 2019.10.24-ний өдөр явуулсан судалгаанд нийтдээ байгууллагын 30 ажилтан оролцсон. Энэ нь 85.71% оролцоотой учраас хангалттай хэмжээний дүгнэлт гаргах түүврийн тоо болсон гэж үзэж байна. Судалгааг авахдаа ажилтнууд өөрийн нэрийг бичих шаардлагагүй байсан нь судалгаанд оролцогчийн зүгээс үнэлгээгээ үнэн зөв, чөлөөтэй бичиж өгөх боломжийг хангасан гэж үзэж байна. Мөн судалгааг бөглөх хугацааг хоёр өдрөөр товлож өгсөн нь ажилтнуудад бодож, нягталж бичих боломжийг бүрэн олгох хангалттай хугацаа</p> |
|--|---|

| | |
|--|--|
| <p>Арга хэмжээ 4.8 "Монгол наадам цогцолбор"-ийн үйл ажиллагааны тогтмол мэдээ мэдээллийг цахим хуудсанд цаг хугацаанд нь тогтмол байршуулан олон нийтэд сурталчилж ажиллана. Үйл ажиллагааны хэрэгжилтээр/</p> | <p>байсан. Ажилчдын хамгийн их сэтгэл хангалуун байгаа үзүүлэлт нь шагнал урамшууллын систем буюу 72% нь сэтгэл ханамжийн үнэлгээтэй гарсан байхад, хамгийн бага нь буюу ажлын нөхцөл 13.3 хувийн үнэлгээтэй гарсан.</p> <p>Байгууллагын ил тод байдлыг хангах чиглэлээр мэдээлэл технологийн ажилтан, нягтлан болон архитекторч нэрт мэдээлэл өгч "Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль", Засгийн газрын 2019 оны 411 дүгээр тогтоолоор батлагдсан "Мэдээллийн ил тод байдлыг хангах журам", Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолоор батлагдсан "Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт" зэрэг хууль журмыг ханган ажилласан. Нийслэлийн Засаг даргын тамгын газрын 2019 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 10/5527 тоот албан бичгээр "Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-ын цахим хуудасны мэдээллийн ил тод байдалд үнэлгээ хийсэн зөвлөмжийг ирүүлсэн бөгөөд 2019 онд 73 хувьтайгаар дүгнэгдсэн. Зөвлөмжийн дагуу ажил сайжруулах төлөвлөгөө боловсруулан газрын даргаар батлуулан хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.</p> |
| <p>Тав. Санхүүгийн тайлан мэдээг хугацаанд нь тайлагнаж өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж ажиллах ажлын хүрээнд</p> <p>Арга хэмжээ 5.1 Санхүүгийн тайлан мэдээ, татвар, нийгмийн даатгалын тайлан болон бусад хугацаат тайлан мэдээг үнэн зөвөөр нь гаргаж, цаг хугацаанд нь тайлагнана. Үйл ажиллагааны хэрэгжилтээр/</p> <p>Арга хэмжээ 5.2 Байгууллагын эд хөрөнгийг тооллогыг хагас жил жилийн эцсээр зохион байгуулна. Үйл ажиллагааны хэрэгжилтээр/</p> <p>Арга хэмжээ 5.3 Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хянаж, ил тод мэдээлэн олон нийтэд сурталчилж ажиллана. Үйл ажиллагааны хэрэгжилтээр/</p> | <p>2019 оны 1-3 дугаар улирлын санхүүгийн тайлан мэдээ, татвар, нийгмийн даатгалын тайлан, 1- 11 сарын төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад хугацаат тайлан мэдээг үнэн зөвөөр гаргаж, хугацаанд нь Нийслэлийн төрийн сан, Нийслэлийн татварын алба, Чингэлтэй дүүргийн нийгмийн даатгалын хэлтэст баталгаажуулсан.</p> <p>"Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-ын даргын 2019 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн А/24 дугаар тушаалаар эд хөрөнгийн эхний хагас жилийн тооллого хийгдсэн. Байгууллагын даргын 2019 оны А/40 тоот тушаалын дагуу эд хөрөнгийн жилийн эцсийн тооллого зохион байгуулах комиссыг байгуулж эд хөрөнгийн тооллогыг хийсэн.</p> <p>http://www.shilendans.gov.mn сайтад 2019 оны 11 дүгээр сарын байдлаар 133 мэдээ байршуулахаас 113 мэдээг хугацаанд нь оруулж 19 мэдээ хугацаа хоцорч оруулж тайланг илгээсэн.</p> |

| | |
|--|--|
| <p>Арга хэмжээ 5.4 Байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг өргөжүүлэх замаар орлогыг нэмэгдүүлж ажиллана. /Үйл ажиллагааны хэрэгжилтээр/</p> | <p>2019 онд нийт 85 сая төгрөг төвлөрүүлэхээс 113 сая төгрөг төвлөрүүлэн ажиллаж байна. 2019 оны 11 дүгээр сарын байдлаар төсөвт төвлөрүүлэх орлогыг 134.0%-иар давуулан биелүүлээд байна.</p> |
| <p>Арга хэмжээ 5.5 Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөнийг холбогдох хууль журмын дагуу шийдвэрлүүлж, хэрэгжилтийг хангаж, өмчийн нэгдсэн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөнийг холбогдох өөрчлөлтийг хийх. /Үйл ажиллагааны хэрэгжилтээр/</p> | <p>2019 оны эхний хагас жилд Нийслэлийн Өмчийн ашиглалт удирдлагын газрын 2019 оны 05 сарын 17-ны 2/570 тоот албан бичгээр ирүүлсэн албан тоотын дагуу 176,896.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө шинээр данс бүртгэлдээ зохих журмын дагуу бүртгэсэн. Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2019 оны 11 сарын 13 өдрийн 3/1640 тоот албан бичгийн дагуу 2019 оны Үндэсний их баяр наадмын төсвийн хөрөнгөөр хийгдсэн нийт 20 000 000 /хорин сая/ төгрөгийн өртөг бүхий Хүй долоон худагт байрлах 10 ширхэг модон гүүрийг хууль тогтоомж, журамд нийцүүлэн холбогдох дансанд бүртгэсэн. Нийслэлийн Өмчийн ашиглалт удирдлагын газрын даргын 2019 оны 10 сарын 29-ны А/380 тушаалаар 37,063.58 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данс бүртгэлээс хассан.</p> |
| <p>Арга хэмжээ 5.6 Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмшиж ашиглах эрх, төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлж санхүүгийн тайланд тусгах үнэлгээний тайлан хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулах. /Үйл ажиллагааны хэрэгжилтээр/</p> | <p>Сангийн сайдын 2018 оны 207 тоот тушаал, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 367-р тогтоол, Байгууллагын даргын 2018 оны А/52 тоот тушаалын дагуу ажлын хэсэг гарган дансанд байгаа барилга байгууламжийн дахин үнэлгээг хийн, өөрийн эзэмшлийн газрыг дансанд бүртгэх ажлыг зохион байгуулсан.</p> |
| <p>Арга хэмжээ 5.7 Хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл хөтөлбөрийн ажлыг ТБОНӨХБАУХА тухай хуулийн дагуу зохион байгуулж НӨХГ-аар хамруулна. /Үйл ажиллагааны хэрэгжилтээр/</p> | <p>2019 онд Төсвийн урсгал санхүүжилтээр Нийслэлийн хэмжээнд Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийг энэ сарын 24-26-ны өдрүүдэд зохион байгуулсантай холбогдуулан 2019 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнөөс Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн өгсөн үүрэг даалгаврын дагуу Хүй долоон худаг дах агуулах, ажлын байрыг бүрэн камержуулсан.</p> |
| <p>Арга хэмжээ 5.8 Батлагдсан төсвийн хүрээнд хийгдсэн ажлын үр дүнд бий болсон хөрөнгийн бүртгэлд авч, үр өгөөжийг тооцож ажиллана. /Үйл ажиллагааны хэрэгжилтээр/</p> | <p>Нийслэлийн өмчийн ашиглалт удирдлагын газрын даргын 2019 оны 05 сарын 17-ны 2/570 тоот албан бичгийн дагуу 176,896.600.0 төгрөгийн Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн Сонгинохайрхан дүүргийн 21-р хороо, Хүй долоон худагт байрлах агуулахын барилгыг халах уурын зуух, мөн 2 ширхэг бохирын нөөцийн савыг холбогдох хууль, журмын дагуу данс бүртгэлд бүртгэсэн. Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын</p> |

| | |
|---|--|
| <p>Зургаа. Хүний нөөцийг чадавхижуулах ажлын хүрээнд</p> <p>Арга хэмжээ 6.1 Ажилчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалтад хамруулж, бие бялдар эрүүл мэндийн сайжруулах чиглэлээр үе шаттай ажил хэрэгжүүлэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн зааварчилгааг тогтмол өгч ажиллана. Үйл ажиллагааны хэрэгжилтээр/</p> | <p>2019 оны 11 сарын 13 өдрийн 3/1640 тоот албан бичгийн дагуу 2019 оны Үндэсний их баяр наадмын төсвийн хөрөнгөөр хийгдсэн нийт 20 000 000 /хорин сая/ төгрөгийн өртөг бүхий Хүй долоон худагт байрлах 10 ширхэг модон гүүрийг хууль тогтоомж, журамд нийцүүлэн холбогдох дансанд бүртгэсэн.</p> <p>"Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-ын ажилтан, албан хаагчдын дотоод нөөц бололцоог нэмэгдүүлэх, хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор жил бүр сургалт зохион байгуулдаг бөгөөд дараах дотоод сургалтад ажилтан алба хаагчдыг 100 хувийн ирцтэйгээр амжилттай хамруулан ажилласан. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1.Улаанбаатар хотын захирагчийн ажлын албанаас зохион байгуулагдсан "Монгол төрийн албан хаагчийн ёс зүй, үнэт өв" сэдэвт сургалтад нийт 11 мэргэжилтэн хамрагдсан. 2.Авилгатай тэмцэх газраас зохион байгуулсан "Авилгын эсрэг 1" сургалтад нийт 15 алба хаагчид 3.НЗДТГ-аас зохион байгуулсан "Хөрөнгө оруулалт" сургалтад нийт нэг мэргэжилтэн 4.НЗДТГ-аас зохион байгуулсан "Илтгэх ур чадвар" сургалтад нийт 2 мэргэжилтэн 5. Нийслэлийн мэдээлэл технологийн газраас зохион байгуулсан сургалтад нийт 2 алба хаагч 6.Нийслэлийн Нийтийн биеийн тамир спортын хорооноос зохион байгуулсан Арга зүйчдийн сургалтад 2 алба хаагч 7.Нийслэлийн тамгын газраас зохион байгуулсан "Хяналтын картыг нэвтрүүлэх" сургалтад нийт 3 мэргэжилтэн 8.НЗДТГ-аас зохион байгуулсан "Гадаад бодлого үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах нь" сэдэвт сургалтад нийт хоёр алба хаагч тус тус хамрагдсан. Тохжилт үйлчилгээний ахлах мэргэжилтэн 3.Очирбат, Мастер Ж.Баяндаваа нар нь албан тушаалын тодорхойлолтын дагуу өдөр тутам Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн анхан болон давтан зааварчилгыг өгч ажиллаж байна <p>Мөн дараах гадаад сургалтад байгууллагад тогтвор суурьшил, үр бүтээлтэй ажиллаж байгаа албан хаагчдаас Удирдлагын академид 3 сар болон 1,5- 2 жилийн захиалгат ангид жилд 2-оос доошгүй албан хаагчдыг хамруулан суралцуулж мэдлэг мэргэжлийн дээшлүүлэх бололцоо олгон ажиллаж байна. Энэ жил Удирдлагын академийн захиалгат 1,5 жилийн ангид эдийн засагч М.Хоролсүрэн,</p> |
|---|--|

| | |
|--|---|
| <p>Ахлах мэргэжилтэн Б.Солонго, Архитектур Б.Балжинням нар суралцаж байна. Мөн Монгол улсын хөдөлмөрийн хууль, OHSAS 18001 стандартын дагуу Хөдөлмөрийн сайдын А/33 тоот тушаалаар батлагдсан хичээлийн хөтөлбөртэй Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад нийт 15 албан хаагчдыг хамруулан сертификиад олгосон ба тус сургалтын байгууллагад Цахилгаанчин Г.Мөнхдорж, Тохжилт үйлчилгээний ажилтан А.Даваасүрэн нарыг Цахилгаанчин, гагнуурчны мэргэжлийн сургалтад хамруулж мэргэжлийн үнэмлэх олгосон.</p> | <p>Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн дугаар 03 тоот " Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам батлах тухай" тогтоолын дагуу нийт алба хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулан удирдлагад танилцуулан хянуулж батлуулан "Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-ын газрын даргын А/01 тоот тушаалаар баталсан. Хөдөлмөрийн дотоод журмын найм дугаар зүйлд заасны дагуу шинэ албан хаагчидтай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байна. Мөн газрын даргын 2019 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/14 дугаар тоот тушаалаар батлагдсан Ес зүйн зөвлөлийн ажиллах журмыг нийт ажилтан, албан хаагчид өдөр тутамдаа мөрдөн ажиллаж тухайлсан журмыг нээлттэйгээр байгууллагын дотоод мэдээллийн самбарт байршуулан ажиллаж байна. 2019 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн газрын даргын А/08 тоот тушаалаар батлагдсан "Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-ын Ажилтан, албан хаагчдад "Ур чадварын нэмэгдэл олгох ажлын хэсэг" -т Ур чадварын нэмэгдлийг дээрх журмын дагуу сар бүр дүгнэж ажиллаж байна.</p> |
| <p>Арга хэмжээ 6.2 Төрийн албаны тухай шинэчилсэн хуулийн холбогдох дүрэм журмыг баримтлан, ажилчидтай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажлын үр дүнг тооцож ажиллана. Үйл ажиллагааны хэрэгжилтээр/</p> | <p>Эрүүл мэндийн сайдын 2018 оны " Хүн амыг нас хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгт хамруулах тухай" А/420 дугаар тушаал болон Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2018 оны 07 дугаар тогтоолын дагуу өөрийн байгууллагын ажилтан, алба хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд 8 сард нийт ажилчдыг зуун хувийн ирцтэйгээр хамруулсан.</p> |

| | | |
|---|--|--|
| Арга хэмжээ 6.4 Ажилчдын ажлын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулахад анхаарч ажиллана. /Үйл ажиллагааны хэрэгжилтээр/ | Байгууллагын нийт ажилчдын цаг ашиглалтыг egr.uiaanbaatar.mn сайтаар ирсэн, явсан цагийг бүртгэлжүүлдэг бөгөөд байгууллагын хэмжээнд давхар цагийн бүртгэл хөтлөн ажиллаж байна. | |
| НИЙТ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТИЙН ДУНДАЖ ОНОО | | |

ХОЁР. ТУСГАЙ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Гэрээнд тусгагдсан тусгай арга хэмжээ тэдгээрийн шалгуур үзүүлэлт (тоо чанар хугацаа үр дүн) бүрээр хүрэх түвшин | Жинхэнэ гүйцэтгэл (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин) | Тухайн тусгай арга хэмжээний биелэлтэд ерөнхийлөн өгсөн үнэлгээ (Нийт арга хэмжээ бүрийн биелэлтэд 0-30 оноо) |
|---|---|---|
| <p>1</p> <p>Долоо. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд туссан ажлыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:</p> <p>Арга хэмжээ 7.1 "Тал нутгийн чимээ" ардын болон үндэсний язгуур урлагийн тоглолтыг задгай талбайд жуулчдад зориулан зохион байгуулан үр дүнг тайлагнан ажиллана. /Хамрагдсан жуулчны тоо/</p> | <p>2</p> <p>"Тал нутгийн чимээ- 2019" ардын болон үндэсний урлагийн тоглолтыг 09 дүгээр сарын 13-нд Хүй долоон худагт зохион байгуулсан. Энэхүү арга хэмжээг 350м2 хэмжээтэй нийт 250 хүний багтаамжтай зориулалтын асар түрээслэн дотор нь ширээ, сандал байрлуулан хүлээн авалтын уур амьсгал оруулж жуулчдыг халуун виноогоор угтан асарт оруулж халуун, хүйтэн уух зүйлс, хөнгөн зууш, десерт, амттанаар үнэ төлбөргүй үйлчилсэн. Тоглолтын асарт 3х4-ийн хэмжээтэй лед дэлгэц угсран байрлуулж "Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-ын танилцуулга шторкыг ирсэн зочдод монгол, англи орчуулгатайгаар үзүүлж сонирхуулсан юм. Тус тоглолтыг монгол хэлээр МҮОНРТ-ын хөтөлгөч Н.Нандинцэцэг, англи хэлээр хөтөлгөч Н.Баяраа нар, Улаанбаатар чуулгын хамт олон цамын бүжиг, уртын дуу, морин хуурын шилдэг номерууд, үндэсний бүжиг, хөгжмийн шилдэг номерууд, монгол ардын дуу, уртын дуу, гоцлол бүжиг, хөөмийн болон нумт хуурын номеруудаа үзүүлсэн, Улаанбаатар циркийн жүжигчид болох Наран, Цэнддаваа нар дэлхийд гайхагдах уран нугаралтын үзүүлбэрийг, МУЭ-ийн гишүүн, СТА Цэнд-Аюуш Монгол уран бичлэг болох каллиграф бичгээр,БГД-ийн хүндэт иргэн Зулзагаа гуай өөрийн гараар урласан Монгол үндэсний оньсон тоглоом болох "Уран бэрийн нүүдэл" тоглоомын түүх болон ач тусыг</p> | <p>3</p> |

| | |
|---|---|
| <p>Арга хэмжээ 7.2 Үндэсний ёс заншил, эрийн гурван наадмыг сурталчилсан "Бэсрэг наадам"-ыг жуулчны улиралд зохион байгуулан үр дүнг тайлагнан ажиллана. /Хамрагдсан жуулчны тоо/</p> | <p>ирсэн зочдод танилцуулсан. "Эра модель энтэрнэйшнл" агентлагийн загвар өмсөгчид монгол үндэсний дээл хувцас болох Халх, Буриад, Баяд, Захчин ардын дээл хувцасны загварыг үзүүлсэн. Мөн "Жонон" хамтлаг үндэсний хөгжмийн тоглолтоо сонирхуулсан юм. Тоглолтын төгсгөлд ДижЭй Агваан 30 минутын хөгжмийн сет тоглож хүрэлцэн ирсэн жуулчид аянд бүжиглэн өнгөрүүлж хөгжилдсөн юм. Энэхүү арга хэмжээнд Турк, Хятад, Герман, Япон, Солонгос зэрэг 5 орны 186 жуулчин ирж сонирхсон юм.</p> |
| <p>Арга хэмжээ 7.3 Хүй долоон худагт хүүхэд залуучуудад зориулан "Морь уналга, сургалт" үйл ажиллагааг тогтмолжуулах үүднээс "Мазаалай эксплор" ХХК-тай 21 хоногийн хугацаанд иж бүрэн уналгын хэрэгсэлтэй 10 морьдыг 5.040.000 төгрөгөөр түрээслэх гэрээ байгуулан хамтран ажиллаа. "Морь уналга, сургалт"-ын төвийг идэвхжүүлэх үүднээс дотоод болон сурагчдын аялал зохион байгуулдаг албан ёсны эрхтэй "Хурд фото тур" ХХК, Аха тур ХХК, "Монгол туургатан" ХХК, Старт трэйвел" ХХК, "Зуун зам" ХХК зэрэг компаниудтай хамтран нийслэлийн ерөнхий боловсролын Чингэлтэй дүүргийн 5, 37, 39, Хан-Уул дүүргийн 18, Баянгол дүүргийн 51, 73, Баянзүрх дүүргийн 102, Сонгинохайрхан дүүргийн 62, 65, 102, 105, 123, 124 дүгээр сургуулиудын нийт 560 орчим хүүхдүүд, Мөн Толът, Олонлог, Хобби, Хишиг, Ертөнц, Номуун зэрэг хувийн сургуулиуд анги болон бүлэг байдлаар хамрагдсан. Энэхүү сургалтын төвөөр улсын ерөнхий</p> | <p>Холбогдох журмын дагуу хөтөлбөр төлөвлөгөөг боловсруулан захирамжийн төслийг Нийслэлийн Засаг даргад танилцуулсан бөгөөд цаг үеийн байдал, хөрөнгийн асуудлаас шалтгаалан 2019 онд хийгдээгүй.</p> |
| <p>Арга хэмжээ 7.3 Хүй долоон худагт хүүхэд залуучуудад зориулан "Морь уналга, сургалт" үйл ажиллагааг тогтмолжуулах үүднээс "Мазаалай эксплор" ХХК-тай 21 хоногийн хугацаанд иж бүрэн уналгын хэрэгсэлтэй 10 морьдыг 5.040.000 төгрөгөөр түрээслэх гэрээ байгуулан хамтран ажиллаа. "Морь уналга, сургалт"-ын төвийг идэвхжүүлэх үүднээс дотоод болон сурагчдын аялал зохион байгуулдаг албан ёсны эрхтэй "Хурд фото тур" ХХК, Аха тур ХХК, "Монгол туургатан" ХХК, Старт трэйвел" ХХК, "Зуун зам" ХХК зэрэг компаниудтай хамтран нийслэлийн ерөнхий боловсролын Чингэлтэй дүүргийн 5, 37, 39, Хан-Уул дүүргийн 18, Баянгол дүүргийн 51, 73, Баянзүрх дүүргийн 102, Сонгинохайрхан дүүргийн 62, 65, 102, 105, 123, 124 дүгээр сургуулиудын нийт 560 орчим хүүхдүүд, Мөн Толът, Олонлог, Хобби, Хишиг, Ертөнц, Номуун зэрэг хувийн сургуулиуд анги болон бүлэг байдлаар хамрагдсан. Энэхүү сургалтын төвөөр улсын ерөнхий</p> | <p>Хүй долоон худагт хүүхэд залуучуудад зориулан "Морь уналга, сургалт"-ын төвийг 2019 оны 06 дугаар сар 20-ний өдрөөс эхлэн нээн ажлуулсан. Энэхүү сургалтын төвөөр амарч тухлах таатай орчинг бүрдүүлэх үүднээс "Грийт тоур" ХХК-тай захиалгаар ажил гүйцэтгэх гэрээ байгуулан 4.400.000 төгрөг үнэ бүхий хоёр сүүдрэвч, "Элст мянган констракшн" ХХК-тай гэрээ байгуулан 8.056.000 төгрөгний өртөгтэй хашааны тохижилтын ажил 3 метр өндөр шонтой гэрэл 8 ширхэг, 60см өндөр явган гэрэлтүүлгүүд, Төмөр шон 4 ширхэг, 15 метр урт морины уяаны олс, хашаан доторх талбайн 0,9 га газрын хөрсийг тэгшилж, засч зүлэгжүүлсэн. Морь уналга, сургалтын төвийн үндсэн үйл ажиллагааг тогтмолжуулах үүднээс "Мазаалай эксплор" ХХК-тай 21 хоногийн хугацаанд иж бүрэн уналгын хэрэгсэлтэй 10 морьдыг 5.040.000 төгрөгөөр түрээслэх гэрээ байгуулан хамтран ажиллаа. "Морь уналга, сургалт"-ын төвийг идэвхжүүлэх үүднээс дотоод болон сурагчдын аялал зохион байгуулдаг албан ёсны эрхтэй "Хурд фото тур" ХХК, Аха тур ХХК, "Монгол туургатан" ХХК, Старт трэйвел" ХХК, "Зуун зам" ХХК зэрэг компаниудтай хамтран нийслэлийн ерөнхий боловсролын Чингэлтэй дүүргийн 5, 37, 39, Хан-Уул дүүргийн 18, Баянгол дүүргийн 51, 73, Баянзүрх дүүргийн 102, Сонгинохайрхан дүүргийн 62, 65, 102, 105, 123, 124 дүгээр сургуулиудын нийт 560 орчим хүүхдүүд, Мөн Толът, Олонлог, Хобби, Хишиг, Ертөнц, Номуун зэрэг хувийн сургуулиуд анги болон бүлэг байдлаар хамрагдсан. Энэхүү сургалтын төвөөр улсын ерөнхий</p> |

| | |
|--|--|
| | <p>боловсролын 13 сургууль, хувийн 6 сургууль, бусад хувь хүн гэр бүл, найз нөхөд гээд 200 орчим хүмүүс үйлчилгээ авсан байна. Нийт энэхүү сургалтын төвөөр үйлчлүүлсэн хүүхэд, залуучууд, бусад хүмүүсээ давахасан тоогоор тооцож үзвэл 760 гаруй орчим хүнд үйлчилсэн байна.</p> |
| <p>Найм. Дүрмээр хүлээсэн үндсэн чиг үүргийн хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлын хүрээнд</p> <p>Арга хэмжээ 8.1 Монгол наадам цогцолборын дэд бүтэц, их засвар /СХД/ /Ажлын гүйцэтгэлээр/</p> <p>Арга хэмжээ 8.2 Салбар хорооноос өгсөн үүрэг, чиглэлийн дагуу Үндэсний Их Баяр Наадмын ажлын төлөвлөгөө гарган тохижилт үйлчилгээний ажлыг хийж гүйцэтгэнэ. /Ажлын гүйцэтгэлээр/</p> | <p>Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/459 дүгээр захирамжийн хавсралтаар батлагдсан Монгол наадам цогцолборын зам дагуух борооны ус зайлуулах суваг, цахилгаан хангамж, гэрэлтүүлгийг сайжруулах засвар шинэчлэлийн ажлыг Нийслэлийн худалдан авах ажиллагааны газраас 2019 оны 06 сарын 06-нд зарлагдаж, НХААГ/201901022 дугаартай тендэрт "Буян нэмэх ингер" ХХК шалгарч 10 дугаар сарын 07-ны өдөр ажлаа бүрэн дуусгаж улсын комисст хүлээлгэж өгсөн. Зам дагуух борооны ус зайлуулах сувгийн ажлын хүрээнд 1400м бетон сувгийг 255 сая төгрөгийн төсвөөр, цахилгаан хангамж гэрэлтүүлгийг сайжруулах засвар шинэчлэлийн ажлын хүрээнд шинээр 910 метр кабель шугам, 3 ширхэг хувиарлах самбар хайрцгийн хамт, нийт 64 ширхэг гэрэлтүүлгийн толгойг солих ажлыг 45 сая төгрөгийн төсвөөр хийж гүйцэтгэсэн.</p> <p>Салбар хорооноос өгсөн үүрэг, чиглэлийн дагуу байгууллагын баг бүрэлдэхүүн нь наадмын зохион байгуулалтын бэлтгэл ажлыг 2 сарын өмнөөс эхлүүлж Хүй долоон худагт Үндэсний их баяр наадмын бэлтгэл ажлыг хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг "Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-ын даргаар 2019 оны 06 дугаар сарын 17-ний өдөр 9 бүлэг 77 ажлыг батлуулж байгууллагын даргын тушаал 1, салбар хорооноос ирсэн төлөвлөгөөний дагуу ажил хариуцан гүйцэтгэх байгууллагын дотоод төлөвлөгөө 1-ыг тус бүр гарган мөрдөн ажиллаа. Нийт бэлтгэл ажлын хугацаанд хамт олны болон удирдлагын түвшинд 9 удаа хуралдаж төлөвлөгөөний гүйцэтгэл, чанарын хэрэгжилт, гэрээт байгууллагуудын ажлын үр дүнг хянан ажиллаж, тулгамдсан асуудлуудыг цаг тухай бүрд нь шийдвэрлэн ажилласан. Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хорооноос 1 удаа, Тохижилт, засвар, худалдаа, үйлчилгээний салбар хорооноос 3 удаа, Хурдан морины салбар хорооноос 2 удаа "Хүй долоон худаг"-т үзлэг шалгалт, комиссын хурал хийж, холбогдох үүрэг даалгавруудыг өгч, тохижилтын ажлын хэрэгжилтийг хянан зөвлөж ажилласан. Баяр наадмын Тохижилт, засвар, худалдаа, үйлчилгээний салбар хорооноос "Монгол Наадам Цогцолбор" ОНӨТҮГ-т 2019 онд</p> |

| | |
|---|---|
| <p>Арга хэмжээ 8.3 Хүй долоон худгийн соёл, урлагийн талбайн зохион байгуулалтыг хариуцан, гар урлал, бэлэг дурсгал, соёлын бараа, хөдөлгөөн тоглоомны зөвшөөрөл олгох ажлыг хариуцан хийж гүйцэтгэж салбар хороонд тайлагнан ажиллана. /Олгосон зөвшөөрлийн тоо/</p> | <p>50,040,800 төгрөг хуваарилсан. Дээрх төсвийг салбар хорооны даргаар батлуулан, төлөвлөлтийн дагуу Хүй долоон худгийн тохижилт, засвар үйлчилгээний ажилд зарцуулан төлөвлөгөөнд тусгагдсан болон төлөвлөсөн ажлуудаа цаг хугацаанд нь чанартай гүйцэтгэж, баяр наадмын бэлтгэлийг бүрэн хангаж ажилласан.</p> <p>"Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ ҮИБН-ын Тохижилт, засвар, худалдаа, үйлчилгээний салбар хорооноос гаргасан удирдамжийн дагуу Хүй долоон худгийн Соёл, урлагийн талбайд нийт 100 ширхэг зөвшөөрөл олгогдсон ба албан ёсны зөвшөөрөл авсан иргэд заасан талбайд байрлан эмх, цэгцтэйгээр худалдаа үйлчилгээг явуулж байлаа. Олгогдсон зөвшөөрлийг төрлөөр ангилбал кофе шоп 5 ширхэг, гар урлал, бэлэг дурсгал, соёлын барааны худалдаа 38 ширхэг, хөдөлгөөнт тоглоомын үйлчилгээ 43 ширхэг, ус ундаа, зайрмаг худалдаа 10 ширхэг, олон нийтэд үйлчлэх зөврийн АТМ машин 1 ширхэг, нэгж худалдаалах үүрэн телефоны машин 1 ширхэг /Мобиком/, гэрэл зураг авах үйлчилгээ 2 ширхэг тус тус ажилласан. Соёл, урлагийн талбайд үйл ажиллагаа явуулж байгаа хөдөлгөөнт тоглоомуудад СХД-ын Мэргэжлийн хяналтын хөдөлгөөнт тоглоом хариуцсан байцаагч, УБ цахилгаан түгээх сүлжээ ХК-ийн ажилчидтай хамтран хяналт тавьж ажилласан бөгөөд шаардлага хангахгүй тоглоомыг дор бүр нь буулган, цахилгааныг нь салгуулан шуурхай ажиллаа. Талбайд байрлалтай цахилгааны шийтүүдэд баяр наадмын өдрүүдэд цахилгааны холболт хийх деспичерийн дугаарыг байршуулан мөн цахилгаан холболтын талаарх зааварчилгааг газар дээр нь олгон аюулгүй байдлыг ханган зохион байгуулалтыг сайжруулан ажиллаа. Хяналтын явцад хүүхдийн бие, эрхтэнд гэмтэл учруулахуйц төрлийн тоглоом хөлсөөр тоглуулаагүй.</p> |
| <p>Арга хэмжээ 8.4 Монгол үндэсний ёс заншил, эрийн гурван наадмыг хойч үедээ өвлүүлэн сурталчлах зорилгоор "Монгол Хүү" хүүхдийн баярыг зохион байгуулж үр дүнг тайлагнан ажиллана. /Хамрагдсан хүүхдийн тоо/</p> | <p>Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан байгууллагын даргын 2019 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн А/22 дугаартай тушаалын дагуу Хүй долоон удагт Монгол үндэсний хэв шинж маягийг агуулсан уламжлалт "Монгол хүү-2019" хүүхдийн баярыг "Гийнгоо" анхдугаар наадам нэрийн дор СХД-ийн ЗДТГ, "Хонгорын шинэ эрин" ХХК, "Хөх морьт" морь уналга, сургалтын төв, "Хонгорын хурд" Морин Спорт Уяачдын Холбоотой хамтран "МОНГОЛ ТУУРГАТНЫ ХУРДАН МОРЬ УНААЧ ХҮҮХДҮҮДИЙГ АЛДАРШУУЛАХ" зорилготой, мөн гэрээгээр "Би Эл Ти Трэйд" ХХК,</p> |

| | |
|--|--|
| <p>Арга хэмжээ 8.5 "Эрүүл иргэн-Эко хөгжил" спорт өдөрлөгийг хүүхэд, залуучуудын дунд зохион байгуулж үр дүнг тайлагнан ажиллана. /Ажлын гүйцэтгэлээр/</p> | <p>"Буман шувуут" ХХК, "Зуун зам трэвел" ХХК хамтран ажиллаа. Энэхүү баярын арга хэмжээнд УБ хотоос, Төв аймгийн Аргалант сум, СХД-ын 32-р хорооноос нийт 218 орчим хүүхэд, урлагийн номер үзүүлэх 100 хүүхэд хүрэлцэн ирсэн бөгөөд "Гийнгоо аялах тэмцээн", "Морины цол дуудах тэмцээн", "Морины дэл сүүл хэн сайн боох вэ" тэмцээнд оролцохоор орон нутгаас 40 орчим хүүхэд, хүүхдийн бөхийн барилдаанд оролцохоор 65 хүүхэд, өсвөрийн сур харваан тэмцээнд оролцохоор 37 хүүхэд буюу нийт давхацсан тоогоор 500 орчим хүүхэд багачууд хүрэлцэн ирсэн. Хүүхдийн баярын арга хэмжээнд оролцсон бүх хүүхдүүдэд "Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-ын удирдлага болон зохион байгуулагчид гарын бэлэг гардуулан энэхүү баярын арга хэмжээ 17:30 минутад дууссан. "Монгол хүү 2019" хүүхдийн баярын арга хэмжээг Хүй долоон худагт зохион байгуулж, төсвийг Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, дагуу 10 434 550 төгрөг зарцуулан ажилласан.</p> <p>"Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-аас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг "Эрүүл иргэн-эко хөгжил" спорт өдөрлөг 5 дахь жилдээ "Хүй долоон худаг"-т 05 дүгээр сарын 24-ний өдөр СХД-ийн ЗДТГ болон тус дүүргийн Биеийн тамир, Спортын хороо мөн тус дүүргийн Боловсролын хэлтэстэй хамтран дүүргийн Ерөнхий боловсролын 9, 12, 42, 62, 65, 74, 76, 105, 107, 121, 122, 123 дугаар зэрэг сургуулиудийн ахлах ангийн 500 гаруй сурагчдын дунд 3х3 сагсан бөмбөг, сонирхогчдын уулын дугуйн марафон, сонирхогчдын холын зайн 3000-5000 метрийн гүйлт, хөгжөөнт буухиа, зэрэг 4-н төрөлт тэмцээнийг эрэгтэй, эмэгтэй гэж ангилна зохион байгуулсан. Өдөрлөгийг Дيامонд продакшны хөтлөгч Деемөө, дуучин Г.Төгөлдөр, СУИС-ын дэргэдэх Квартит хамтлаг, UB dance бүжгийн клубийн багш нар флаш мобо бүжиг заан, "Монголын экстрем дугуй сонирхогчдын холбоо"-ны тамирчид үзүүлбэр үзүүлсэн. Нийт энэхүү 4-н төрөлт тэмцээний нийлбэр оноогоор үнэмлэхүй амжилт гаргаж түрүүлсэн спорт өдөрлөгийн шилдэг сургуулиар Б.Ачиймаа багштай 105-р сургуулийг "Эрүүл иргэн – Эко хөгжил -2019" спорт өдөрлөгийн нэрэмжит "ШИЛДЭГ СУРГУУЛЬ"-иар өргөмжилж цом, өргөмжлөл, дурсгалын зүйл мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан.</p> <p>Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд "Монгол</p> |
|--|--|

| | |
|---|---|
| | <p>наадам цогцолбор" ОНӨТҮГ-аас жил бүр уламжлан зохион байгуулдаг "Айраг фестиваль-2019" наадмыг Монголын морин спорт уяачдын холбоо зохион байгуулж буй "Их хурд VIII"-тай хамтатган Хүй долоон худагт 2019 оны 7 дугаарын сарын 20,21нд зохион байгууллаа. Айраг фестивалийн нээлтийн арга хэмжээнд нийтдээ 3000 гаруй үзэгч, оролцогчид цугларсан бөгөөд Баярын үеэр дэмбээ, айраг хэн сайн уух вэ?, уламжлан ирсэн хамгийн сайхан хөхүүр, найрын дууны аварга, чөдөр, ногт хэн сайн зангидах вэ? гэх мэт найрыг хөгжөөх уралдаан тэмцээнүүдийг шалгаруулдаг уламжлалтай. Уралдаан тэмцээнд оролцох хүсэлтэй нийтдээ 100 гаруй хүн бүртгүүлж 6н уралдаан, тэмцээний 1,2,3-р байр шалгаруулж нийтдээ 18 хүн шагнаж урамшуулав. Ийнхүү айраг фестивалийн хүрээнд зохион байгуулагдаж байгаа тэмцээн уралдаан маань олон нийтийг хамарч үзэгч олныг баясаж чадсан наадам болж өндөрлөлөө. Айраг фестиваль нь Монгол орны хөхүүрийн айрагны соёлыг түгээгч өвлөн уламжлагч түүнийг шимтэн уух дуртай "айраганд дурлагсад"-ын талархлыг хүлээсэн баяр болоод байгаа билээ. Айраг фестивалаар дамжуулан улс орон даяаар хөхүүрийн айрагны онцлог ач холбогдол, хөхүүрийн айрагтай холбоотой зан үйлийг сурталчлах томоохон индэр болж буй юм. Айраг фестивалийн үр дүнд хөдөө орон нутгийн амьдарлаас хол байдаг нийслэл хотын залуус болон жуулчдад хөхүүрийн айраг түүнтэй холбогдох зан үйл мөн монгол уламжлалт идээ будааг таниулах зорилгоор Айраг фестивалийг зохион байгуулсан нь ийнхүү үр дүнтэй болж өндөрлөлөө.</p> |
| <p>Арга хэмжээ 8.6 "Айраг фестиваль"-ыг зохион байгуулан үйл ажиллагааг сурталчлан үр дүнг тайлагнан ажиллана. /Ажлын гүйцэтгэлээр/</p> | <p>Төр болон хувийн хэвшлийн түншлэлийг идэвхжүүлэх ажлын хүрээнд энэ жил "Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ "Монголын хөнгөн атлетикийн холбоо" ТББ-тай 2019 оны 6 дугаар сарын 12-ны өдөр Спортын төв ордонд хамтран ажиллах санамж бичиг байгуулсан. Энэхүү санамж бичгийн гол зорилго нь Хүй долоон худагт 2019 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр "Тал нутгийн монгол" Олон улсын марафон гүйлтийн тэмцээнийг хамтран зохион байгуулах болон бусад спортын уралдаан тэмцээн, бүх нийтийн арга хэмжээг зохион байгуулахад хамтран ажиллах, хоорондын ажлын уялдаа холбоог ханган харилцан дэмжлэг үзүүлж үйл ажиллагааны бодит үр дүнд хүрэхэд оршиж байгаа юм. Хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурах үйл ажиллагаанд STAR телевиз, MNB спорт сувгийн</p> |
| | <p>Арга хэмжээ 8.7 Хүй долоон худагт олон нийтийн хамарсан соёл,урлаг,аялал жуулчлал,спортын үйл ажиллагаа зохион байгуулах чиглэлээр Төрийн болон төрийн бус</p> |

| | |
|--|---|
| байгууллага, холбоод, хэвийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллана. /Ажлын гүйцэтгэлээр / | сурвалжлагч нар болон setvvv/ch.mn, taamaa.mn портал сайтуудын сэтгүүлч нар ирж сурвалжлага хийн ярилцлага авсан юм. Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Монголын оюутны холбоо, "Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ хамтарч "Цэвэрхэн наадамцагаа" аяныг 2 дахь жилдээ Хүй долоон худагт зохион байгууллаа. Тус аяны хүрээнд Хүй долоон худаг орчимд 90 оюутан 3 өдөр ажиллаж, хоггүй цэвэр орчинд баярлахыг наадамчин олонд уриаллаа. Наадамчид "Цэвэрхэн наадамцагаа" уриатай самбарыг хараад хогоо хогийн саванд хийж хэвшиж байсан. Тус оюутнууд ажлын 8 цагаар наадамчин олон болон үйлчилгээний байгууллагуудад уриалга түгээн, "Хүй долоон худгийн байршлын хөтөч" схем зургийг наадамчдад тараан, мөн замдаа тааралдсан хогийг цэвэрлэн, Хүй долоон худгийн орчимд илэрч буй хогийн цэг, хогийн савнуудад хяналт тавин шаардлагатай тохиолдолд "Монгол наадам цогцолбор"-т мэдээлэлж байсан. Монгол наадам цогцолбор тухайн мэдээлэл бүрийг цаг тухайд нь талбайн хог цэвэрлэгээ хариуцсан 2 байгууллагад мэдэгдэн цэвэрлүүлж ажиллаа. |
| ТУСГАЙ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТИЙН ДУНДАЖ ОНОО ГУРАВ. МАНЛАЙЛЛЫН ЗОРИЛТЫН БИЕЛЭЛТ | |

| | | |
|---|---|--|
| Гэрээнд тусгагдсан манлайллын зорилт (орц) түүний шалгуур үзүүлэлт бүрээр хүрэх түвшин | Жинхэнэ гүйцэтгэл (шалгуур үзүүлэлт бүрээр хүрсэн түвшин) | Тухайн манлайллын зорилтын биелэлтэд төсвийн ерөнхийлөн захирагчийн өгсөн үнэлгээ (манлайллын зорилт бүрийн биелэлтэд) |
| 1. Төрийн албаны тухай хууль, тогтоомж, стандарт, ёс зүйн хэм хэмжээг чанд сахих, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх: Зорилт-1. Авилгын эсрэг хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон | 2 А. Ашиг сонирхлын зөрчил, авилгаас ангид байхтай холбоотой хууль тогтоомжийг сахин биелүүлэх, хувийн ашиг сонирхлын, хөрөнгө орлогын мэдүүлгийг Газрын дарга, Орлогч дарга, ахлан нягтлан бодогч нар авилгатай тэмцэх газар хөрөнгө орлогын мэдүүлгээ хуулийн хугацаанд гаргаж тайлагнасан. Ажлын байрны тодорхойлолтуудыг ажилтан тус бүр дээр гаргаж авилгатай тэмцэх тухай хууль болон ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх заалтыг оруулан ажиллалаа. | 3 |

| | |
|---|--|
| <p>бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах</p> <p>Зорилт-2. Төрийн удирдах албан хаагчийн ёс зүйг сахих</p> | <p>Б. Ёс зүйн харьцаа хандлага хэм хэмжээг баримтлан үйл ажиллагаагаа явууллаа.</p> <p>В. Байгууллагын ажилтнуудыг эрхэмлэн дээдэлж тэдний санал хүсэлт, санаа бодлыг сонсож санал санаачлагын дагуу хөдөлмөрийн дотоод журманд нэмэлт өөрчлөлт оруулж ажиллаа.</p> |
| <p>2. Байгууллагын ил тод байдлыг хангах</p> | <p>А. "Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-ын үйл ажиллагааг ил тод байлгах үүднээс www.mnts.ub.gov.mn вэб сайтыг ажиллуулан дээд байгууллагаас гаргасан манайтай холбоотой дүрэм, журам, журам улсын болон нийслэлийн тогтоол, захирамжийг цаг алдалгүй өөрийн сайтад тогтмол байршуулах, мөн Ubservice.mn болон мэдээллийн портал сайтуудад мэдээллэж ажилласан. Монгол наадам цогцолбор вэб сайт нь дэргэдээ /Монгол наадам цогцолбор/ facebook хуудастай бөгөөд тус хуудсаараа дамжуулан мөн адил сайтад дээр тавьсан мэдээлэл болон заруудыг тогтмол оруулж, тус байгууллагын талаар гарсан бусад хэвлэл мэдээллийн хэрэгсэл, вэб сайтад дээрх мэдээллийг холболт хийн оруулж олон нийтэд хүргэж байна. Мөн http://www.shiendans.gov.mn сайтад санхүүгийн ил тод байдлын мэдээллийг оруулж ажиллаж байна.</p> <p>Б. Иргэдээс ирсэн санал, хүсэлтийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж онд ажилласан бөгөөд иргэд болон ажилчдаас нийт 196 өргөдөл гомдол ирснийг egr.ulaanbaatar.mn сайтад бүртгэн хуулийн хугацаанд нь шийдвэрлэн ажиллаа.</p> |
| <p>Зорилт-1. Байгууллагын нээлттэй, ил тод байдлыг хангах, нийслэлийн иргэдэд нийтийн үйлчилгээг чанартай, хурдан шуурхай хүртээмжтэй үзүүлэх</p> <p>Зорилт-2. Байгууллагын өмнө тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх</p> <p>Зорилт-3. Зорилтот жилийн хүрээнд төлөвлөсөн ажлыг хийж гүйцэтгэх</p> | <p>В. "Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-т олгогдсон улсын тусгай хэрэгцээний газрын давхцалын асуудлыг шийдвэрлэх талаар санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга Т.Гантөмөрөөр ахлуулсан ажлын хэсэг байгуулагдаж ажиллаж 2019 онд тусгай хэрэгцээний газрын хэмжээ хилийн зааг өөрчлөлт орсны улмаас Төв аймгийн Аргалант сумын нутаг дэвсгэрт хамаарах 12,031 га газраас 2006 га газрыг улсын тусгай хэрэгцээний газраас чөлөөлж, шинээр 449 га газрыг нэмэх байдлаар нийт 10,474 га газрыг улсын тусгай хэрэгцээнд авах асуудлыг Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 5 дугаар тогтоолоор батлуулж</p> |

| | |
|---|---|
| | <p>Нийслэлийн СХД-ийн нутаг дэвсгэрт хамаарах газрын асуудлыг НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, 2019 оны 12 дугаар сарын 26-ны өдөр НИТХ-аар хэлэлцүүлэн Нийслэлийн Засаг даргаас Барилга хот байгуулалтын яаманд хүргүүлсэн.</p> <p>Г. Монгол наадам цогцолборын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг Нийслэлийн хот байгуулалтын хөгжлийн газрын захиалгын дагуу Нийслэлийн зураг төслийн хүрээлэн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тодотголыг хийж гүйцэтгэсэн бөгөөд газрын хилийн цэсийн өөрчлөлт хийгдсэний дараа баталгаажуулна.</p> <p>Д. "Монгол наадам цогцолборын" ОНӨТҮГ-ын 2019 оны "Гүйцэтгэлийн төлөвлөгөө"-ний дагуу Хүй долоон удаг дахь хурдан морины уралдааны зохион байгуулалт, тохижилтыг сайжруулах зорилгоор Энэ жилийн УИБН-ын өдрүүдээр буюу 07 дугаар сарын 10, 11, 12, 13-ны өдрүүдэд Хүй долоон удагт давхацсан тоогоор 45 мянга орчим хүн хүрэлцэн ирсэн бөгөөд нийт 1000 иргэнээс судалгаа авснаас 836 судалгаа хүчинтэй тоологдсон. Судалгааны тайланг УИБН-ын тохижилт, засвар, худалдаа, үйлчилгээний салбар хороо болон Хурдан морины салбар хороонд тус тус хүргүүлэн ажиллаж байна.</p> |
| | <p>А. Байгууллагын санхүүгийн тайлан мэдээг хугацаанд нь үнэн зөв гаргаж, Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох хуулийг хэрэгжүүлж ажилласан.</p> <p>Б. Байгууллагын санхүүгийн мэдээллийг http://www.shilendans.gov.mn сайтад 2019 оны 12 дугаар сарын байдлаар 133 мэдээ оруулахаас 114-г хугацаанд нь оруулсан үлдсэн 19 мэдээг тодорхой шалтгааны улмаас хугацаа хоцорч мэдээ тайланг байршуулсан.</p> <p>В. Нийслэлээс батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулан ажиллаж байна.</p> |
| <p>3. Төсвийн хөрөнгийн төлөвлөлт , зарцуулалтын ил тод байдлыг хангах талаар:</p> <p>Зорилт-1.Шилэн дансны хуулийг хэрэгжүүлэн ажиллана.</p> <p>Зорилт-2. Худалдан авах үйл ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулна.</p> | |

| | | |
|--|---|--|
| | <p>Г. "Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланд хийгдсэн аудитын дүгнэлтээр ирүүлсэн зөвлөмжийн дагуу хийгдсэн ажлын биелэлтийг 2019 оны 07 дугаар сарын 22-ний өдрийн 150 тоот албан бичгийн хавсралтаар Нийслэлийн засаг даргын тамгын газрын санхүү, төрийн сангийн хэлтэст тус тус хүргүүлж ажилласан.</p> | |
| | <p>А. "Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-ын даргын 2019 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн А/24 дугаар тушаалаар эд хөрөнгийн эхний хагас жилийн тооллого хийгдсэн. Байгууллагын даргын 2019 оны А/40 тоот тушаалын дагуу эд хөрөнгийн жилийн эцсийн тооллого зохион байгуулах комиссыг байгуулж эд хөрөнгийн тооллогыг хийж байна.</p> <p>Б. Үндсэн хөрөнгийн ашиглалтын талаар хууль тогтоомжоор хориглосон үйл ажиллагаа явуулаагүй.</p> <p>В. Байгууллагын машин, техник тоног төхөөрөмжийн нөөцийг бүрэн хүчин чадлаар нь ажиллуулж, урсгал засвар үйлчилгээг "Форвард моторс" ХХК, Формула ХХК, зэрэг мэргэжлийн компаниудаар цаг тухай бүрт хийлгэсэн. Мөн машин, техник хэрэгсэл болон хариуцлагын даатгалыг "Хаан даатгал" ХХК компаниар хийлгэсэн.</p> | <p>4. Байгууллагын эд хөрөнгийн зохистой ашиглах талаар</p> <p>Зорилт-1. Үр ашигтай хөрөнгө оруулалт хийх, үндсэн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах</p> |
| | <p>А. Байгууллагын даргын 2017 онд батлагдсан хүчиннөөцийн хөгжлийн хөтөлбөрийн дагуу 2019 оны сургалтын төлөвлөгөөг баталсан бөгөөд гадаад сургалтад давхардсан тоогоор нийт 22 албан хаагч хамрагдсан. Дотоод сургалтад давхардсан тоогоор нийт 35 албан хаагч хамрагдсан.</p> <p>Б. Байгууллагын хүний нөөцийг батлагдсан орон тоонд багтаан бүрэн хүчин чадлаар ажиллуулж байна.</p> <p>В. Эрүүл мэндийн сайдын 2018 оны " Хүн амыг нас хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгт хамруулах тухай" А/420 дугаар тушаал болон Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2018 оны 07 дугаар тогтоолын дагуу өөрийн байгууллагын ажилтан, алба хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд 8 сард нийт ажилчдыг зуун хувийн ирцтэйгээр хамруулсан.</p> | <p>5. Байгууллагын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх талаар</p> <p>Зорилт-1. Байгууллагын хүний нөөцийн менежментийг сайжруулах</p> <p>Зорилт-2. Байгууллагын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг хангаж ажиллана.</p> <p>Зорилт-3. Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллана.</p> |
| <p>МАНЛАЙЛЛЫН ЗОРИЛТЫН БИЕЛЭЛТИЙН ДУНДАЖ ОНОО</p> | | |

ТӨСВИЙН ШУУД ХҮЛЭЭХ ҮҮРГИЙН ХУВЬД

| | |
|---|--|
| <p>1.5 Үйл ажиллагаандаа Захиргааны ерөнхий хууль, Төрийн албаны тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль Төсвийн тухай хууль болон өөрийн эрхлэх асуудлын хүрээний холбогдох бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллана</p> | <p>Захиргааны ерөнхий хууль, Төрийн албаны тухай хууль, Шилэн дансны ил тод байдлыг хангаж, дээр дурдсан бусад холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах, байна. Мөн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг ханган хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд нь гарган ажиллаж байна. мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> |
| <p>1.6 Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуульд заасан бодлогын баримт бичгийн уялдаа холбоог хангаж, Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны "Аз жаргалтай хот" мөрийн хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл"-ийг байгууллагын жилийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж, хөтөлбөрийн биелэлтийг Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны даргад тайлагнаж, үр дүнт Засаг даргын өмнө хариуцна.</p> | <p>Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны "Аз жаргалтай хот" үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.4.2 дахь заалт, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд туссан Тал нутгийн чимээ этник шоун тоглолтыг зохион байгуулж ажилласан.</p> |
| <p>1.7 Улаанбаатар хотын "Хөгжлийн индекс"-ийн шалгуур үзүүлэлтүүдийг сайжруулан Хүй долоон хэдгийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэн Бүх нийтээр мод тарих өдөрлөгийг зохион байгуулж ажиллана.</p> | <p>Улаанбаатар хотын "Хөгжлийн индекс"-ийн шалгуур үзүүлэлтүүдийг сайжруулах үүднээс Ерөнхийлөгчийн 2010 оны 63-р зарлигийн дагуу бүх нийтээр мод тарих өдөрлөгийг Хүй долоон худагт зохион байгуулж орчны ногоон байгууламжийг нэмэгдүүлэн ажиллаж байна.</p> |
| <p>1.8 Хүй долоон худаг зохион байгуулагдсан Үндэсний Их Баяр наадам болон бусад олон нийтийн арга хэмжээний зохион байгуулалт тохижилтийн үр дүнг Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт /KPI/-ээр үнэлнэ.</p> | <p>Үндэсний Их баяр наадмын зохион байгуулалт бэлтгэл ажлын хүрээнд "Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-тай гэрээ байгуулан ажилласан аж ахуй нэгжийн хийж гүйцэтгэсэн тохижилтын ажлыг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт /KPI/-ээр үнэлж ажилласан.</p> |
| <p>1.9 2019 оны "Иргэдийн оролцоотой- Хөгжлийн жил" болгон зарласантай холбогдуулан энэхүү ажлын хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлж ажиллана.</p> | <p>2019 оны "Иргэдийн оролцоотой- Хөгжлийн жил" болгон зарласантай холбогдуулан УИБН-ын хурдан морины уралдаан болон зохион байгуулалт тохижилтыг сайжруулах зорилгоор Үндэсний Их баяр наадмын үеэр наадамчдаас сэтгэл ханамжийн судалгаа авч үр дүнг нь холбогдох газруудад хүргүүлэн ажилласан. Мөн үндэсний спортын холбоод, аялал жуулчлалын төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцуулан Монгол наадам цогцолборын өнөөгийн байдал ирээдүйн чиг хандлага сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулсан.</p> |

| | |
|---|---|
| <p>1.10 Байгууллагын хэмжээнд тулгамдаж буй шийдвэрлэх цаардлагаатай асуудлаар 2-оос доошгүй ажлыг санаачилж хэрэгжүүлэн ажиллана.</p> | <p>Нийслэл хотын 380 жилийн ойг тохиолдуулан Хүй долоон худгийн оффис болон агуулах, гэр бааз орчмыг бүрэн камержуулан ажилласан мөн Монгол наадам гэр баазаар үйлчлүүлэгчдийн ая тухтай байдлыг хангах үүднээс өөрсдийн нөөц бололцоог ашиглан хүүхдийн тоглоомын талбайг тохижуулан ажилласан.</p> |
| <p>1.11 2018 оны байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнд үнэлгээ өгсөн ажлын хэсгээс ирүүлсэн зөвлөмжид тусгагдсан ажлуудын тусгай төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, хагас бүтэн жилийн тайлангийн хамт үр дүнг үнэлэн Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газрын Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтэст хүргүүлнэ.</p> | <p>Монгол наадам цогцолбор ОНӨТҮГ-ын 2018 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын хэсгээс 2019 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн 03/444 тоот албан бичгээр Нийслэлийн Засаг даргын тамгын газрын хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын хэсгийн 2019 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 06 тоот зөвлөмж ирсэн. Энэхүү зөвлөмжийн дагуу ажил сайжруулах төлөвлөгөөг 13 ажилтайгаар батлуулан 2019 оны 37 тоот албан бичгээр хүргүүлсэн. Энэ төлөвлөгөөний хагас жилийн биелэлтийг 2019 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 137 тоот албан бичгээр жилийн эцсийн биелэлтийг 2019 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 272 тоот албан бичгээр хүргүүлэн ажиллаж байна.</p> |
| <p>1.12 Албан үүргээ гүйцэтгэхдээ нэгдмэл сонирхолтой болон хамаарал бүхий этгээдтэй холбоотойгоор олон нийтэд төрийн албан хаагч, төрийн албанд эргэлзээ төрүүлэх, итгэлийг алдах шинжтэй аливаа үйлдэл, эс үйлдэхүй гаргахгүй байна.</p> | <p>Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн талаар нийт ажилчид, албан хаагчдад хууль сурталчилан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган албан хаагчдыг Авлигын эсрэг 1 сургалтад хамруулан хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд нь гаргаж ажиллаа.</p> |
| <p>1.13 Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд төсөв санхүүгийн сахилга батыг чанд мөрдөж ажиллана</p> | <p>Нягтлан бодох тухай хууль, Төсвийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдөн батлагдсан төсвийн хүрээнд өр төлбөргүй орлогоо давуулан биелүүлж ажилласан.</p> |
| <p>1.14 Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж, шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээ, мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцан ажиллана.</p> | <p>http://www.shilendans.gov.mn сайтад 2019 оны 11 дугаар сарын байдлаар 133 мэдээ байршуулахаас 113 мэдээг хугацаанд нь оруулж 19 мэдээ хугацаа хоцорч оруулж тайланг илгээсэн.</p> |
| <p>1.15 Байгууллагын өмч хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар аливаа гэрээний биелэлт, гүйцэтгэл үр дүнг Нийслэлийн засаг даргын өмнө хариуцаж ажиллана.</p> | <p>Нийслэлийн засаг даргын 2018 оны 07 сарын 02-ны 597 тоот захирамжийн 2-т заасны дагуу Нийслэлийн өмчийн удирдлага ашиглалтын газартай "Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-г байгуулан улирал бүр үр дүнг тайлагнан ажиллаж байна</p> |
| <p>1.16 Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дундын мэдээллийн сан www.erg.ulaanbaatar.mn цахим хуудсыг ашиглана.</p> | <p>edos.gov.mn албан бичгийн нэгдсэн системийг өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж байгаа бөгөөд 2019 онд нийт 238 бичиг ирж, 269 бичиг явсаныг edos.gov.mn системд тухай бүр бүртгэн ажиллаж байна. Цаг тухайд нь албан бичгийн шийдвэрлэн ажиллаж байна. Мөн 196 өргөдөл гомдлыг бүртгэж хуулийн хугацаанд нь шийдвэрлэж ажиллаа.</p> |

| | |
|---|--|
| <p>1.17 Эрхлэх асуудлын хүрээнд шүүхэд үүссэн маргаанд Нийслэлийн Засаг даргыг төлөөлж оролцох бөгөөд үүсэх аливаа үр дагаврыг Засаг даргын өмнө бүрэн хариуцна.</p> | <p>Эрхлэх асуудлын хүрээнд шүүхийн байгууллагад маргаан үүсээгүй.</p> |
| <p>1.18 Байгууллагын албан хаагчдын албан тушаалын ангилал, зэрэглэлийг Засгийн газрын 2007 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 354 дүгээр тогтоол, албан хаагчдын цалинг Засгийн газрын 2019 оны 24 дүгээр тогтоолыг тус тус баримтлан ажиллана.</p> | <p>Байгууллагын албан хаагчдын албан тушаалын ангилал, зэрэглэлийг Засгийн газрын 2007 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 354 дүгээр тогтоолыг баримтлан ажиллаж байгаа бөгөөд, албан хаагчдын цалинг Засгийн газрын 2019 оны 24 дүгээр тогтоолын дагуу байгууллагын даргын 2019 оны 01 сарын 21-ны А/04 тоот тушаала гаргуулан үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> |

Тайлан бичсэн:

Монгол наадам цогцолбор
ОНӨТҮГ-ын дарга

Төсвийн шууд захирагч


2020 оны 1 дүгээр сарын 5 /Д.Хатанбаатар/

Үнэлгээ өгсөн:

Нийслэлийн Засаг дарга бөгөөд
Улаанбаатар Захирагч

Төсвийн ерөнхийлөн захирагч

2020 оны 1 дүгээр сарын 5
С.Амарсайхан